**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**
Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.04.17 № 3/1896

танай _____ -ны № _____ -т

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т.СҮХБОЛД ТАНАА

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 01 дугаартай албан даалгаврыг хүргүүлэв.

Албан даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг улирал тутам нотломжийн хамт ирүүлнэ үү.

Хавсралт 6 хуудастай.

Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Төрийн нарийн бичгийн дарга
Нэргүй Мягмар
2026.04.17 17:49

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2026 оны 04 сарын 16 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Хууль зүй, дотоод хэргийн салбарын
үйл ажиллагаа, ажлын бүтээмжийг
дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг
сайжруулах талаар

Хууль зүй, дотоод хэргийн салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүн, нийгэмд үзүүлэх нөлөөллийг дээшлүүлж, сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор харьяа агентлаг, байгууллагуудын дарга (захирал) нарт Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ДААЛГАХ нь:

Нэг.Харьяа байгууллагын үйл ажиллагаа,
ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр

1.1.Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаа, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, төрийн албаны стандартыг хэрэгжүүлж, хариуцсан үүргээ харилцан уялдаатай мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;

1.2.Салбарын үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн чиг үүрэгт учирч болох аюул, эрсдэлийг бодитой тодорхойлох дүн шинжилгээ хийж, магадлал, нөлөөллөөр нь эрэмбэлэн, эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

1.3.Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй тэгш хүргэж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулсан, хүн төвтэй, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах;

1.4.Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн алба хаагчдыг мэргэшүүлж, тогтвор, суурьшилтай ажиллуулах, мэргэжлийн албыг бэхжүүлэх;

1.5.Иргэдийн эрх зүйт төрд итгэх итгэл, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу судалж, асуудлыг үндэслэлтэй эцэслэн шийдвэрлэх, хуулийн хугацаанд хариуг өгч ажиллах;

1.6.Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр цахим шилжилтийг эрчимжүүлж, хариуцсан салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухааныг ашиглах;

1.7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй байлгах бөгөөд нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн 2025 оны үнэлгээгээр хууль зүй, дотоод хэргийн салбарын хэмжээнд 61.6 хувьтай үнэлэгдсэн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байх тул хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, дүнг 2026 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

151000043

1.8.Үндэсний аудитын газрын зөвлөмжийг хэрэгжүүлж, төрийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчилгүй, цаг хугацаанд нь зохион байгуулах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулах;

1.9.Албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа, хуулиар зөвшөөрөгдсөн нэмэгдэл, урамшуулал, тэтгэмж, ээлжийн амралт, нөхөн төлбөрийг бүрэн олгох, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авч, алба хаагчдыг мэргэшүүлэх дотоод, гадаадын сургалтад хамруулах;

1.10."Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2026 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах ажлын ачааллыг бууруулах, тайлан, мэдээг эрэмбэлэн, нэгтгэн гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгож, байгууллагын дотоод журамдаа өөрчлөлт оруулах.

Хоёр.Албан тушаалтнуудын сахилга хариуцлага,
дэг журмыг сайжруулах чиглэлээр

2.1.Удирдах албан тушаалтнуудын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэн, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн алба хаагчийн ёс зүйн хэмжээг чанд сахиж, үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлан ажиллах;

2.2.Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгохоос сэргийлж, албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;

2.3.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, авлигад өртөж болзошгүй албан тушаалын жагсаалтыг гаргаж, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, 2026 оны 5 дугаар сард танилцуулах;

2.4.Сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа асуудлыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан, хүлээлгэх хариуцлагыг чангатгах;

2.5.Улс төрөөс ангид, нөлөөлөлд автахгүй, хуулийн үндэслэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, иргэдийн итгэл, хүлээлт, шаардлагад нийцэж ажиллах;

2.6.Хүний эрхийг зөрчсөн, хязгаарласан, хийдэлтэй дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлуудыг шуурхай шийдвэрлэх;

2.7.Сахилга, хариуцлага, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд албан тушаалтан бүр мэдрэмжтэй, идэвх зүтгэл, сэтгэл гаргаж, хариуцлагатай байх.

Гурав.Агентлаг, байгууллагын дарга (захирал) нарт:

Энэ онд манай улсад зохион байгуулагдах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP-17) болон "Дэлхийн адууны өдөр" 10,000 морьтны парадын бэлтгэлийг хариуцсан чиглэл тус бүрээр хангаж, зөрчил, дутагдалгүй оролцоход анхаарах.

Цагдаагийн ерөнхий газар

1.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг чанд мөрдөж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн ажиллах;

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;

3.Өсвөр насны хүүхдүүдийн дунд гарч буй үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалтын нөхцөл байдалд улсын хэмжээнд дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран хэрэгжүүлж, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;

4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлж, илрүүлэлт, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ шатанд гарган, олон улсын жишиг, үйл ажиллагааны стандартыг судалж, нэвтрүүлэх, шаардагдах төсвийг шийдвэрлүүлэх чиглэлээр санал, судалгаа танилцуулж, хэрэгжүүлэх;

5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоог сайжруулж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, гаргасан гомдол, мэдээллийг шуурхай, тэргүүн ээлжид шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх;

6.Нийгэмд түгээмэл үйлдэгдэж байгаа тодорхой төрлийн гэмт хэрэг, тэр дундаа кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт, таслан зогсоох чадавхыг нэмэгдүүлж, олон нийтийн цахим орчны хэрэглээтэй холбоотой эрсдэлийг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

7.Нийгмийн анхаарал татсан гэмт хэрэг, зөрчил, онц ноцтой үйл явдалд авах хариу арга хэмжээг шуурхай, ил тод, нэгдсэн удирдлагаар хангаж, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэх, байгууллагын нэр хүнд, иргэдийн итгэлийг сэргээх ажлыг тогтмолжуулах:

8.Улс төр, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нам, эвсэл, иргэний нийгмийн байгууллагуудаас зохион байгуулагдах жагсаал, цуглаан зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалтыг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд сайтар төлөвлөн хэрэгжүүлэх.

Хил хамгаалах ерөнхий газар

1.Монгол Улсын хилийн тухай хуулийн хэрэгжилтэд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран үнэлгээ хийлгэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дүгнэлт, саналаа танилцуулах;

2.Хилийн бүс, зурваст үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, үр дүнг тооцох;

3.Баянхонгор, Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт хамаарах хилийн алслагдсан хэсгийг камерын хяналтад шилжүүлэн, тоон радиорелейн системд холбох, Баян-Өлгий,

Увс, Завхан аймаг дахь хилийн цэргийн ангиудын хариуцсан хэсэгт хилийн торон саадыг байгуулж, хил хамгаалалтад шилжүүлэх;

4.Хилийн “Чингис хаан”, “Алтанбулаг”, “Гашуунсухайт”, “Боршоо”, “Замын-Үүд” боомтод хиймэл оюун (AI)-д суурилсан царай болон автомашины дугаар таних систем суурилуулан туршиж, үр дүнг танилцуулах;

5.Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын сахилга хариуцлагад анхаарч, цэрэг халах, татах болон шинэ дайчдын цэргийн анхан шатны сургалтын төвийн үйл ажиллагааг зөрчил, дутагдалгүй зохион байгуулах.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

1.Шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр төлбөр төлөгч, төлбөр авагч, иргэн, хуулийн этгээдийг мэдээллээр хангаж, хийсэн ажиллагаа, бодит байдлыг тодорхой тайлбарлан ойлгуулж, хамтарч ажиллах, мэдээлэл өгдөггүй, утсаа авдаггүй, эргэж холбоо барьдаггүй гэх шалтгаанаар өргөдөл, гомдол их гарч байгаад дүн шинжилгээ хийж, дахин давтан гаргахгүй байх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллах;

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид иргэд, хоригдол, хоригдогч, бусад хүмүүстэй харьцахдаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Үйлчилгээний стандарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилга, ёс зүйн дүрмийг эрхэмлэж, төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай хүргэх зарчмыг баримтлан ажиллах;

3.Барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шийдвэрлэсэн, хөрөнгө, орлого тогтоогдсон төлбөр гаргуулах ажиллагааг шуурхай явуулах, хууль хэрэглээний болон хугацааны зөрчил гаргахгүй байх;

4.Хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичигт бүс нутгийн амьжиргааны доод түвшинд нийцүүлэн тэтгэлгийн тооцоо, тулгалт хийх, хуримтлал үүссэн гүйцэтгэх баримт бичигт албадлагын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;

5.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар хөрөнгө, орлого тогтоогдоогүй гүйцэтгэх баримт бичигт хуульд заасан үндэслэл, журмын дагуу төлбөрийг хэсэгчлэн төлүүлэх ажлыг зохион байгуулах;

6.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирол, төлбөр олгосон гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж, санд буцаан төвлөрүүлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх;

7.Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, тэтгэлгийн хуримтлал үүссэн, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх үндэслэлийг сайтар хянаж, шуурхай шийдвэрлэх;

8.Хоригдол, хоригдсон болон баривчлагдсан, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээд, шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлэх иргэн оргох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, харуул хамгаалалтын биечилсэн хяналтыг бүх шатанд тасралтгүй зохион байгуулах;

9.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас ангид байж, хоригдол, хоригдсон болон баривчлагдсан

этгээдийн эрхийг хангах, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх тусгайлсан сургалтыг албан хаагч нарт тогтмол зохион байгуулах;

10.Хоригдлуудаар аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай нэг бүрчлэн танилцуулж хөдөлмөрт хамруулах, үйлдвэрлэл, гэрээт хэсэг болон хорих ангийн гадна хөдөлмөр эрхэлж буй хоригдлын аюулгүй байдлыг хангах, гэм хорын хохирол төлбөрийг барагдуулахад анхаарах.

Улсын бүртгэлийн ерөнхий газар

1.Албан хаагч тус бүр улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хуулийн хугацаанд чирэгдэлгүй, шуурхай үзүүлж, цаг хугацаанд нь шийдвэрлэх, иргэний хандалт, давтамжийн тоог бууруулахад онцгой анхаарч ажиллах;

2.Иргэн, хуулийн этгээдээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдуулан гаргасан санал, гомдолд дурдсан асуудал, зөрчил, маргааныг судлан, үүсэж байгаа шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад өөрчлөлт оруулах чиглэлээр санал танилцуулах/санаачилгатай ажиллах.

3.Улсын бүртгэлийн үйлчилгээнд дэвшилтэд техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглан төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, нийгмийн даатгал, татвар, халамжийн байгууллагатай мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах, цахим төрийн тогтолцоонд шилжих нөхцөл бүрдүүлэхэд анхаарч ажиллах.

Архивын ерөнхий газар

1.Төрийн архивуудын үйл ажиллагаанд улсын үзлэгийг зохион байгуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах;

2.Монгол-Оросын архивын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын гэрээний дагуу комиссын 28 дугаар хуралдааныг тогтоосон хугацаанд амжилттай зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, ОХУ-ын Архивын байгууллагатай нягт хамтран ажиллах;

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд улсын үзлэг зохион байгуулсан дүнг Засгийн газарт танилцуулсантай холбогдуулан гаргасан Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.

Гадаадын иргэн, харьяатын газар

1.Гадаадын иргэн, харьяатын газарт ашиглаж буй “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийн хөгжүүлэлтэд онцгой анхаарч, гадаадын иргэдэд виз олгох үйл ажиллагааг ойлгомжтой, шуурхай болгоход анхаарах;

2.Гадаадын иргэдэд тавих хяналтыг сайжруулж, Монгол Улсаас гадаадын иргэдийг албадан гаргах ажлыг сайжруулахад анхаарч, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх.

Дотоод хэргийн их сургууль

1.Онол, практикийн уялдаа холбоог сайжруулж, дадлага, сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэмэгдүүлж, шинэ шатанд гаргах;

3.Судалгааны үр дүнг бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглуулах;

4.Кибер аюулгүй байдал, дижитал мөрдөн шалгах чиглэлийн сургалтыг хөгжүүлэх;

5.Сургуулийн багш ажилчид, бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг өндөржүүлж, сургалтад ашиглаж байгаа галт зэвсэг, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хадгалах агуулах, байрыг байнга хяналт, хамгаалалтад байлгаж, аюулгүй байдлыг хангах.

Хууль зүйн туслалцааны төв

1.Үйлчлүүлэгч төвтэй, чанартай, үр дүнтэй хууль зүйн туслалцааг үзүүлэх, улсын өмгөөлөгчдийг мэргэшүүлэхэд анхаарах;

2."Хиймэл оюунд суурилсан хууль зүйн зөвлөгөө өгөх систем"-ийн хөгжүүлэлтийг дуусгаж, иргэд хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг цахимаар шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.Хууль зүйн туслалцааны төвийн нийслэл болон орон нутаг дахь салбарын ажлын байранд тавих шаардлагыг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг

1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид анхаарч, эмч мэргэжилтнүүдийн ур чадвар, харилцаа, хандлагыг сайжруулахад чиглэсэн олон талт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.Олон улсын эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн байгууллагын давтан үнэлгээнд бэлтгэл ханган хамрагдаж, холбогдох зөвшөөрлийг сунгуулах.

Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр үр дүн гарахуйц бодит ажил, арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг улирал тутам тайлагнаж байхыг харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудад үүрэг болгож байна.

Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож, ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмарт даалгасугай.

С.АМАРСАЙХАН